

Жигзавын Дорждагва - Монголын мэргэжлийн найрал дууны урлагийг үндэслэгч мөн

Цэндийн Наранчимэг ✉ 

Соёл урлагийн их сургуулийн Соёлын сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
✉ ttsn91@gmail.com

Жигдэнгомбын Цэцэн

Соёл урлагийн их сургуулийн Соёлын сургууль,
Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: Монголын шинэ үеийн соёл урлагийн салбарын нэрт зүтгэлтэн, Ж.Дорждагва нь дуу хөгжмийн урлагийн тулгын чулууг тавилцсан, их мастер, анхдагч мэргэжилтэн юм. Тэрээр дундад зууны үеэс өрнөдөд хөгжиж эхэлсэн дуу хөгжмийн онолын шинжлэх ухаанд өөрийн төрөлхийн авьяас билиг, мэдлэг, чадвараа дайчлан XX зууны монголын урлагт ая эгшгийн шинэчлэлийг 1930-аад оноос хийж эхэлсэн юм. Тэр цагаас ЗХУ-ын мэргэжилтнүүд удаа дараа ирж хамтран ажиллахын зэрэгцээ дэлхийн хөгжмийн онолын үндсийг зааж сургаснаар монгол залуус өөрсдийн сонирхол, идэвхээр богинохон хугацаанд амжилттай суралцаж хэрэгжүүлсэн талаар олон баримт, ноот тэмдэглэл, эх бичмэлүүд үлджээ.

Ж.Дорждагвын үндсэн ажил нь уртын дуучин байсан хэдий ч аялгуу зохиох, найрал дууны онолын бүтцийг бие даан судалж, олон хоолойны урлаг дээр үндэснийхээ уламжлалт аялгууг дэлхийн шинжлэх ухааны онолтой хослуулан хөгжүүлж, өөрийн гэсэн цоо шинэ аргачлалыг бий болгож чадсан байдаг. Энэ нь дараа үеийн найрал дууны удирдаачдын цаашдын зам мөрийн анхны шонг татаж өгсөн гэж үзэх үндэслэлтэй.

Шинэ цаг үеийн нийгмийн төлөв байдалд зохицон шинэ мэдлэг эзэмших, хэрэгжүүлэх олон талт ажлыг хийж гүйцэтгэхэд учирч байсан саад бэрхшээлийг даван туулсаар орчин цагийн дуу, хөгжмийн болон найрал дууны хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан гавьяатан билээ.

Жигзавын Дорждагвын найрал дууны хөгжилд оруулсан үнэтэй хувь нэмрийн талаар эрдэмтэн судлаачид, найрал дууны мэргэжилтэнүүдтэй харилцан ярилцаж, мэдээлэл цуглуулах ярилцлагын аргыг ашиглаж, тэмдэглэл хөтөлж үнэн бодит хэрэгцээт мэдээллийг бүрэн цуглуулахаар ажиглалтын аргыг ашиглаж дүгнэлтийг хийлээ.

Түлхүүр үгс: зохиомж, санаа, урлаг судлал, урлагийн онол, төрөл ойлголт

Dorjdagva Jigzav: Founder of professional choral music art in Mongolia

Naranchimeg Tsend ✉ 

School of Culture, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
✉ tstsn91@gmail.com

Tsezen Jigdengombo

School of Culture, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: A visible figure in the cultural and artistic circles of the new generation of Mongolia, J.Dorjdagva is a great master and innovator, who laid the cornerstone of musical art. He was a pioneer of musical reform in Mongolian art in the 20th century, beginning in the 1930s, using his natural talent and knowledge in the field of music theory, which began to develop in the West during the Middle Ages.

Since then, many documents, notes and original compositions have been preserved, testifying to the fact that Mongolian youth successfully mastered and applied the basics of world music theory in a short period of time thanks to their own interest and enthusiasm, while specialists from the Soviet Union repeatedly came to cooperate.

Although the main profession is J.Dorjdagva was a singer who independently studied the theory of melodic composition and choral structure, developed his own unique method, combined traditional national melodies with world scientific theories in the art of polyphony. It can be assumed that this laid the foundation for the further path of the choir of conductors.

He is a person who made a significant contribution to the development and establishment of modern songs and music, overcoming obstacles in his multifaceted work to acquire and implement new knowledge in accordance with the social conditions of the new era.

The conclusions were drawn by discussing the valuable contribution of J.Dorjdagva to the development of the choir with scholars and experts in choral art, using the interview method to collect data, taking notes and using the observation method to fully collect factual and useful information.

Keywords: *composition, idea, art studies, art theory, concept of tyre*

Оршил

Найрал дуутай холбоотой эрх зүйн баримт

26 (1936) оны 2 дугаар сарын 12-нд анхны захирал Д.Нямтайсүрэн (1937-1940) Ардын Сайд нарын Зөвлөлийн Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч сайд, улсын /маршал/ өрлөг жанжны даалгавраар Улсын төв театрын ажил хэргийг өргөтгөн хөгжүүлэх тухай тодорхойлолтод "...тус театрын дуу хөгжмийн ажил хэрэг нь нэлээд амжилттайгаар хөгжиж, монгол дуунуудыг ноотод оруулж, хэвлэн нийтлэх хийгээд мөн дуучин нөхдийг ноотны мэргэжилтэй болгохыг оролдоод

буй ба урт, богино дуунуудыг пянзаар оруулж дуулсан зэрэг бүтээлтэй зүйлүүд буй боловч шинэ хүчнийг төрүүлэх, залуу залуу хөгжимчин дуучдыг олшруулах, сургах явдал дутам бөгөөд мөн аливаа дуу хийгээд хөгжмүүдийг сонирхолтой зааж дуулах, хөгжимдөх, шинэ боловсронгуйгаар хичээн үл явуулах буюу мөн тус театрын дуучин нь ганц нэг зүгийн аялгууг онцлон явуулж буй бөгөөд олон нийтийн буюу газар газрын аялгууг үл хэрэгсэх нь ард түмний захиас сургаалын тал дээр дутагдалтай байна. Иймийн тул эрхбиш дээр дурдсан зүйлүүдийг гүйцээн явуулах хийгээд газар газрын аялгуу зэргийг хослон хэрэглэвээс зохих болой” (Монгол Улсын консерватори 2017, 18) гэжээ.

БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн Ерөнхий сайдын 1937 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 45 дугаар тушаалаар Ардыг гэгээрүүлэх яамны харьяа “Театрын дэргэдэх уран сайхны сургууль”-ийг байгуулжээ.

Ардын гэгээрүүлэх яамны дэргэд байсан Улс төрийн уран сайхны зөвлөлийг өргөтгөж, Сайд нарын Зөвлөлийн дэргэд 1938 оны 1 дүгээр сарын 28-нд “БНМАУ-ын Уран сайхны хэрэг эрхлэх хүрээлэн” байгуулсан байна.

...Тус сургуульд хот хөдөөгөөс элсүүлэн авах сурагчдыг улс төрийн зан байдал хийгээд уран сайхны талаар тэдний авьяас, мэргэжил ямар, ямар чинагшид уран сайхны үндсэн ажилчин болж чадах эсэх болон бусад боловсролуудын талаар туйлын сайтар шалган авах комиссыг байгуулах нь чухал тул комиссын даргад тус хүрээлэнгийн Театр, клубын хэлтсийн байцаагч Баатар, Төв театрын мэргэжилтэн сургагч В.Боройшо, мөн театрын орлогч дарга Л.Цэрэндорж, Ж.Дорждагва, сургуулийн захирал Д.Нямтайсүрэн нарыг томилж, уул шалгалтын ажлыг одоогоос эхлэн ажиллан энэ сарын 30-ны өдөр зохих актыг гаргаж ирүүлэхийг комиссын дарга гишүүдэд даалган тушаасугай (МУУТА. х.13, д. 1, хн. 14, 31).

...Сургуулийн боловсон хүчний асуудлыг нэн тэргүүнд шийдвэр гаргаж энэ тухай гавьяат багш М.Цэрэндорж, мэргэжлийн багш нь алдарт дуучин Ж.Дорждагва, Ц.Төмөр, хөгжимчин Л.Цэрэндорж, Д.Ишдулам, Ө.Лувсан, Л.Маам, Д.Түдэв, С.Түвдэн, О.Дашдэлэг, солгой Б.Баяр, жүжигчин Ц.Цэгмид, Т.Хандсүрэн, Д.Ичинхорлоо, Б.Жадамбаа, найруулагч Э.Оюун, Д.Намдаг, театрт уригдан ирж ажиллаж байсан мэргэжилтэн Б.Смирнов, Н.Бельский, В.Я.Романовский, С.Гольперин, А.Рабинович, К.Рушев, В.Борейшо нар байсан бол ерөнхий эрдмийн хичээлийг Ц.Шаравнямбуу, Б.Цэвэгжав, Ч.Палаан, Д.Жамьяндагва зааж байжээ.

...Улсын театр 32 хорчид /найрал дуучид/, 12 солист /гоцлол дуучид/-уудтай болжээ. Эдгээр нь цөм Ф.И.Клешкогийн сургасан хүмүүс юм. Түүнчлэн, Ф.И.Клешко үндэсний хормейстрүүдийг төрүүлэх талаар Л.Цогзолмаа, Ж.Дорждагва, Д.Лувсаншарав нарыг сургав. Ф.И.Клешкогийн уран бүтээлч, багшлагч өндөр чадвар ганц хоолойгоор дуулдаг монгол дуунуудыг дөрвөн хоолойгоор дуулах болгосон ба манай дуучид зөвхөн үндэсний дуунуудыг дуулах биш, зөвлөлт ба орос хийгээд дэлхийн сонгодог бүтээлүүдээс тоглож чадах болсон талаарх тэмдэглэлүүд байна.

Судалгааны арга зүй

Судалгаандаа Ж.Дорждагвын зохиосон найрал дууны талаар архивт хадгалагдсан баримтад тулгуурлан нэмэлт мэдээлэл олж авах зорилгоор урьдчилан

бэлдсэн асуултын дагуу эрдэмтэн судлаачид, найрал дууны мэргэжилтнүүдтэй харилцан ярилцаж, мэдээлэл цуглуулах ярилцлагын аргыг ашигласан ба ярилцлагын явцад тэмдэглэл хөтөлж үнэн бодит хэрэгцээт мэдээллийг бүрэн цуглуулахаар ажиглалтын аргыг ашиглан нэгтгэн дүгнэсэн болно.

Судалгааны үр дүн

Найрал дууны анхны хормейстрээр 1940-өөд оны дунд үед Ж.Дорждагва томилогдон ажиллаж олон арван дууг найруулан толилуулсан байна. 1941-1960 оны хөгжмийн урлагт дууны уран бүтээл голлох байрыг эзэлж байсан. Л.Мөрдорж, Б.Дамдинсүрэн, С.Гончигсумлаа, Лха.Дорж, Д.Лувсаншарав зэрэг уран бүтээлчид уран бүтээлийнхээ замыг эхэлсэн ба хөгжмийн зохиолчид тухайн цаг үеийн үйл явдлыг тусгасан бүтээл туурвиж байв. 1950-аад оны үед социализм байгуулах үйлсийг удирдаж байсан намаа магтан дуулах, ажил хөдөлмөр, мал аж ахуйн сэдэв уран бүтээлчдийн нэг үндсэн чиглэл болж ирэв. Энэ үед Ж.Дорждагва “Туулай би”, “Цуурай”, “Манай нам”, “Малынхаа дэргэд”, “Онгийн голын домог”, “Ильич мину” найрал дуугаа зохиожээ.

1950 онд Ардын армийн үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим, дагшаа найрал хөгжмийн уран бүтээл хурдацтай хөгжиж, шинээр олон бүтээл зохиосоор байв.

1943 онд Улсын төв театрт хамтлаг байгуулахад Ж.Дорждагва оролцон түүнд шадарлан таван жил ажиллаж, улмаар найрал дууны мэргэжилтэн болтлоо өссөн байна. Тэрээр “Шарай голын гурван хаан” жүжгийн Гэсэр мэргэний дуу, “Мандухай цэцэн хатан”-ы Бүүвэйн дууг ардын ахуй, билиг зүйг сайн мэддэг зохиолчийн барилаар зохиосон гэж судлаачид үзсэн байна (Болд 2014, 34). 1942 онд Б.Дамдинсүрэн, Б.Ф.Смирнов нар “Учиртай гурван толгой” дуурийг бичихэд Ж.Дорждагва “Нарны дуу”, “Бүүвэйн дуу”, “Найрын дуу” (Лувсанжамцын Цогзолмаа 2013)-г зохиож оролцсон. Ж.Дорждагва нь жинхэнэ хөрсний дуучин учраас эдгээр аялгуунуудыг монгол ардын урт болон богино дууны аялгуу шиг маш гайхамшигтайгаар зохион туурвисан юм.

Хөгжмийн урлагт найрал дууны төрөл маш чухал үүрэг гүйцэтгэдгийг харуулсан олон хөгжмийн зохиолч хормейстр (найрал болон гоцлол дуучдыг дасгалжуулдаг багш)-үүдийн бүтээлүүд бий.

Ж.Дорждагва нь Монгол Улсын театрын анхны найрал дууны удирдаач мэргэжилтэн. Тухайн үеийн хөгжмийн зохиолч, найрал болон гоцлол дуучидтай ажилладаг байсан нь орчин үеийн удирдаач нар уламжлан үргэлжлүүлэн хөгжүүлсээр ирсэн. Тэдний тод төлөөлөгчдөд Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын жүжигчин, Төрийн шагналт, хөгжмийн зохиолч Дагвын Лувсаншарав (1927-2014), Монгол Улсын Ардын жүжигчин, Урлагийн гавьяат зүтгэлтэн, найрал дууны удирдаач, хөгжмийн зохиолч Дашийн Мясүрэн (1928-1984), Урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч, Монгол Улсын филармоны “Баянмонгол” чуулгыг үндэслэн байгуулагч, найрал дууны удирдаач Төмөрийн Чимэддорж (1921-1986), хөгжмийн нэрт зохиолч, найрал дууны удирдаач Гончигдамбын Дарамзагд (1930-1980) болон тэдний залгамж үеийн олон найрал дууны удирдаач хөгжмийн зохиолчдыг дурдаж болох юм.

Найрал дууны удирдаач болгон хөгжмийн зохиолч байдаггүй ч Ж.Дорждагвын гаргасан замаар уран бүтээлээ эхэлсэн эхэн үеийн хормейстрүүд бүгд хөгжмийн

зохиолч байсан нь түүний үлгэрлэн үлдээсэн өв байсан. Тухайн үеийн уран бүтээлчид зохиол бүтээлээ олны хүртээл болгохын тулд тэр үеийн (Жанцанноров 2014) нийгмийн үзэл бодол, удирдагчдын хувийн ааш араншинд тохируулахын зэрэгцээ монголын соёл урлагийн хөгжлийг орчин цагийн түвшинд гаргаж хөгжүүлэх зорилгоор уран бүтээлээ туурвиж байсан баримт архивт хадгалагдсаар ирсэн.

Улсын төв театр (1931), Уран сайхны сургууль (1937)-д анхны мэргэжлийн дуулаачийн багш, Улсын хөгжимт драмын театр (1942)-ын анхны найрал дууны удирдаач, Монгол Улсын Алдарт гавьяат дуучин (1935), XX зууны Манлай уртын дуучин (1999) Ж.Дорждагва нь 1960-аад он хүртэл хөгжмийн бүтээл туурвихдаа Монголд шинэ тутам эхэлсэн европын хөгжмийн онолыг ЗХУ-ын сургагч багш нараар заалгаж, ихээхэн чармайлт гарган бие даан идэвхийлэн суралцаж найрал дууны анхны хормейстр болтлоо өссөн байна.

Монголд найрал дууны төрөл хэлбэрийнхээ хувьд уртын дууны түрлэг, хурдан морины гийнгоо, сурын уухай зэрэг байсан гэж ойлгож болно. Монголын найрал дуу бол онолын хувьд дэлхийн сонгодог найрал дууны хэлбэрээс их өөр ялгаатай. Энэ талаар эрдэмтэн судлаач Н.Жанцанноров дүгнэн хэлэхдээ “Найрал дуу байгуулагдахад оросын мэргэжилтнүүдийн оролцоотойгоор Дорждагваас өөр тийм авьяастай, тийм чадвартай, тийм боловсролтой, тухайн үедээ найрал дууг аваад явах манлайлагч байх боломжгүй байсан. Европын найрал дууны суурийг тавьчихаад АДБЧ-аа уламжлалт найрал дуу руу буцаж эргэж ороход нь, өөрөөр хэлбэл, европын олсон мэдлэгээс буцаж өөрийнхөө зүйлийг сэргээхэд УАДБЧ-ын найрал дууг дахин өөрөө сэргээж бий болгосон. Тийм учраас Дорждагва бол европын дэг сургуультай найрал дууны гол үндэслэгч бөгөөд уламжлалт дуугаа найрал дууны аргаар хэрхэн дуулах вэ гэдэг арга зарчмыг тогтоож өгснөөрөө монголын найрал дууны гол удирдагч нь мөн гэж хэлэх ёстой” (Жанцанноров 2014).

Ж.Дорждагвын зохиосон зарим найрал дууны бүтээлүүдэд шинжилгээ хийж харьцуулан гаргалаа.

Хэлэлцүүлэг

Ж.Дорждагва нь 1949 онд Дорнод аймгийн театрт дууны багшаар ажиллаж байхдаа “**Малынхаа дэргэд**” дууг 4 хоолойн өнгөөр зохион найруулсан нь монголд олон хоолойгоор дуулах урлагийг хөгжүүлэх анхны эхлэлийг тавьсан юм. Энэ дуу нь 1949 онд ноот, үгийн хамтаар нэг хуудас цаасан дээр өнгөтөөр Урлагийн хэргийг эрхлэх хороо 1000 ширхэг хэвлэсэн байна (Урлагийг эрхлэх хороо 1949, 1).

Түүний үзсэнээр аялгуу нь одоо сонсоход бүдүүн тойм төдий гэхээр байдаг. Учир нь 5 өнгө, 7 өнгө хоёрын уялдааг зохицуулахад ихээхэн төвөгтэй, эсрэг тэсрэг хоёр хоорондоо мөргөлдөөд байгаа тэр цаг үед шинэ соёл руу орох гээд хуучин соёлыг халахыг нь халаад авч үлдэхийг нь авч үлдэхээс өөр аргагүй цаг үе байлаа. Уламжлалт хэлбэрийг нь алдагдуулахгүйгээр тайлбартайгаар түгээн дэлгэрүүлж хадгалах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, анхных болон орчин цагийн гэсэн хоёр хувилбар хийх нь зүйтэй.

Ж.Дорждагва 1948-1950 онд Дорнод аймгийн ХДТ-ыг анх байгуулахад “Малынхаа дэргэд” найрал дууг зохиосон ба Эрэгзэнгийн Чойдог (1926-1988)

оркестрт /оркестровка/ бичиж найруулсан ч (МУУТА. х. 13, д. 1, хн. 260) тухайн үед телевиз, радиогийн архивт бичлэг болон үлдээгүй байна¹.

“Малынхаа дэргэд” найрал дуу бол акапелла буюу дан найрал дуу ба европын хөгжмийн урсгал орж ирэх гэж байх үед бичигдсэн байна. Энэ бүтээл нь нийгмийн захиалгаар хийгдсэн байж болох талтай бөгөөд үндэсний баялаг болсон хөдөө аж ахуйн хөгжил дэвшлийг гардан зохион байгуулж байгаа малчдынхаа ажил хөдөлмөрийг дэмжсэн, магтан дуулсан сэдэв дээр үндэслэн ая, үг нь зохиогдсон байдаг.

Түүх түүхээрээ үлддэг тул тэр үеийн монголчуудын нийтлэг сэтгэлгээнд удирдагчийг бишрэх хандлага ноёлж байсантай холбогдуулан төрийн тэргүүнээр ажиллаж байсан Хорлоогийн Чойбалсангийн нэрийг оролцуулснаараа дөнгөж хөл дээрээ тэнцвэрээ олж ядаж байсан монгол хөгжмийн зохиолчдын бүтээл рүү элдэв үзэл бодолтнууд, харь сэтгэлтнүүд дайрах халдлагыг намжааж байсан нь тодорхой харагддаг.

78 нэм 894.21 "Уг ба хөгжмийг" ДОРЖДАГВА
А - 542

МАЛЫНХАА ДЭРГЭД

Агаараас нар мишээн халаах
Алсаас жигүүртэн гангинан ирэх
Ургац ногоо цэцэглэн дэлгэрэх
Урьхан сайхан хавар болоход

Урьхан саяхи талыг илж
Уулын хормой хөхрөн харагдаад
Сайн малчид сүргийнхээ дэргэд
Сайхан уянгат дуугаа аялна.

Түмэн малаар хотоо дүүргэж
Төгс жаргалаар араа баясгаж
Хамаг монгол үндэстэн бид нар
Хавтай сайхан жарган цэнгцгээе

Урьхан саяхи талыг илж
Уулын хормой хөхрөн харагдаад
Сайн малчид сүргийнхээ дэргэд
Сайхан уянгат дуугаа аялна.

Мянгаар тоолох төлөө бойжуулж
Түмээр тоолох малаа үржүүлж
Маршал Чойбалсангийн эрхэм сургаалыг
Малчин бид шамдаж биелүүлнэ.

Урьхан саяхи талыг илж
Уулын хормой хөхрөн харагдаад
Сайн малчид сүргийнхээ дэргэд
Сайхан уянгат дуугаа аялна.

Зураг 1. “Малынхаа дэргэд” дуу²

“Малынхаа дэргэд” бүтээл нь тухайн цаг үед Өрнийн хөгжмийн онол бүрэн дүүрэн нэвтрээгүй найрал дууны жүжигчид бэлтгэгдээгүй байсан учраас сайн дурын уран сайханчид, ажилласан хугацаагаараа мэргэжлийн гэсэн үнэмлэхтэй дуучдын сонсгол, хоолойны чадварт тааруулан хоёр хоолой дээр хийгджээ.

Гэхдээ нэг зүйлийг анзаарахад бусад /Ж.Дорждагваас хойших/ хөгжмийн зохиолчдын бүтээлд мөн энэ бэрхшээлийг даван гарахын тулд монгол үндэсний

¹ 1950 оны Чойбалсан аймгийн театрын жилийн төлөвлөгөө гүйцэтгэл, үндэсний оркестр, захиргаа аж ахуйн ангийн жилийн ажлын тайлан илтгэл, төсөл театрын шинэ барилгын тухай материалуудын дугаар 5-д 1950 онд үндэсний оркестрт тоглосон зүйлүүд нь: Гурав. Хор дууны 13-т “Малынхаа дэргэд” Эрэгзэнгийн Чойдог (1926-1988) оркестрт /оркестровка/ бичиж найруулсан.

² Эх сурвалж: Монголын Үндэсний номын сангийн фонд

эгшиг зохицох ёсыг баримтлан пентатоникийн юмуу, эсвэл диатоникийн хөдөлгөөнийг ихэвчлэн ашиглан Дорждагва багшийн загвараар найрал дууны олон хоолойн партитурыг бичих нь хэвшил болсон байдаг нь түүний баримталж байсан монгол найрал дууны чанд бичлэгийн арга барил юм. Өөрөөр хэлбэл, хоолой болгон өөрийн гэсэн монголжуу аялгууны зохицолтой байхаар тооцоолно гэсэн үг юм. Одоо үеийн хөгжмийн зохиолчид полифонийн үндсэн ойлголттой болсон тул аялгуугаа тэдний уламжлалын дагуу аль болох пентатоникийн бүтэцтэйгээр хийхийг хичээдэг ч гармонизацийн хувьд эгшиг зохирлын аргачлалыг хроматизмын орчинд чөлөөтэй ашиглаж байгаа билээ. Энэ нь нэг талаараа хүний хөгжлийн хувьслыг харуулж байгаа ч нөгөө талаараа үндэсний эгшиглэгээний орчноосоо салж хагацах тийм сайн биш дохиолол юм.

Ж.Дорждагвын үлдээсэн өв бол хэн хүний анзаарч мэддэггүй авьяас мэдлэг боловсрол шаарддаг, энэ нарийн хөдөлмөрийн ухааныг монгол хөгжмийн соёлын язгуур дээр бий болгон төлөвшүүлсэн явдал юм.

“Малынхаа дэргэд” зохиол нь дан найрал дууны бүтээл бөгөөд эртнээс дайны ялалт, хурим найрын цэнгэл дээр олноороо дуулдаг төрлийг гаргуун эзэмшсэн монголчуудын хувьд хөгжмийн шинжлэх ухаанаар тогтоогдсон, тодорхой хэмжээ хэмнэл дээр, тодорхой тактанд захирагдсан аялгууг тодорхой бичиж заасан 2-3 өнгөөр салгаж дуулна гэдэг бол 1940-өөд оны үед цоо шинэ үзэгдэл байлаа.

“Малынхаа дэргэд” дуу нь мөн үндэсний уламжлалт хөгнөөс мэргэжлийн онол руу шилжүүлсэн Ре минор дээр бичигдсэн байдаг ба салж буй хоолойнууд биеэ даасан дуучдын сонсгол төөрөхөөргүй аялгууны хөдөлгөөнтэй байгаа нь тухайн үеийн анхны монгол маягийн фуга хэлбэрүүдийн нэг гэж хэлж болохоор байдаг. Фуга гэдэг нь хөгжмийн шинжлэх ухаанд найрал дууны төрөлд байдаг хамгийн том хэлбэрүүдийн нэг бөгөөд XVII-XVIII зууны германы хөгжмийн зохиолч И.С.Бах (1685-1750), Ф.Гендель (1685-1759) нарын бүтээлд онцгой үүрэг гүйцэтгэж байсан.

Үүнээс үзэхэд, дэлхийн сонгодог хөгжим мөн л найрал дуугаар алс холын замынхаа гарааг эхэлж байсныг Дорждагва багш олж харсан нь бүтээлүүдээс нь харагддаг.

“Малынхаа дэргэд” дууны үгийг мөн өөрөө зохиосон бөгөөд үг, ая хоёр нэг хүнээс гарна гэдэг нь уран бүтээлийн язгуур санаа нэг цогц байхын жишээ юм. Ийм туурвилын жишээ хүн төрөлхтөнд олон байдаг ч зохиогчийн уран бүтээл анх үүсэж байсан Монгол орны хувьд бараг үгүй байсан байж болох бөгөөд хамгийн анхных ч байх магадлалтай.

“Малынхаа дэргэд” дуунд 4/5, 4/4, 4/3 гэсэн холимог размеруудыг ашигласан байгаа нь байгалийн чөлөөт хэмнэлээс гарч чадахгүй байсан цаг үед онолын үүднээс олж хараад нэг талаасаа онолын юм шиг мөртлөө нөгөө талаасаа дуулахад мэдэгдэхээргүй хийсэн байгаа нь хэдийгээр мэргэжлийн боловсрол эзэмшээгүй ч гэсэн Ж.Дорждагвын хувьд хөгжмийн зохиолч, найрал дууны удирдаач хүний сийрэг ур ухаантай холбоотой юм.

“Ильич мину” найрал дуу. 1950-аад оноос хойш гадаадад боловсрол эзэмшсэн найрал дууны багш, хөгжмийн зохиолчид, удирдаачид (Д.Мяасүрэн, Б.Дамдинсүрэн нар Ленинградад), (Д.Лувсаншарав, Э.Чойдог, Л.Мөрдорж нар

Москвд) төгсөж ирсэн нь монголын хөгжимд язгуур пентатоникоос диатоникийн орон зай руу шилжих хандлага бий болсон байж магадгүй юм. Энэ нь мөн уран бүтээлчдийн дунд нөлөөлөх нь дамжиггүй бөгөөд 1960 оны сүүлээс хийсэн бүтээлүүдэд нь онолын чанд бичлэгийн зүгээс заавал тэгш таван хөг байх албагүй гэсэн хандлагууд харагдаж эхэлсний нэг нь “Ильич мину” дууны бүтээл юм. МҮОНРадиогийн “Эфирт гаргахыг хориглоно” НТ 48 Алтан сан хөмрөгийн 1970 оны 4 дүгээр сард тоглосон “Ахмадын цуурай” хамтлаг В.И.Лениний 100 жилийн ойд зориулсан концертын хөтөлбөрийн 3 дугаарт “Ильич мину” дууг найрал дуучид 2 бадаг дуулж, Ж.Дорждагва удирдсан байна. Хугацаа: 2 минут 33 секунд үргэлжилжээ. Нийслэл хотын өндөр настнуудаас бүрдсэн “Ахмадын цуурай” чуулгаас В.И.Лениний 100 жилийн ойд зориулсан концертын бүрэлдэхүүнд Ардын хувьсгалын ахмад партизан, улсын алдар цолтой уран бүтээлчид, Хөдөлмөрийн баатар Д.Даваажав тэргүүтэй хөдөлмөрийн тэргүүний ажилчид, Улсын гавьяат багш Намсрай тэргүүтэй соёл урлагийн тэргүүний ажилтнууд, Ардын жүжигчин Д.Ичинхорлоо, Т.Хандсүрэн, Улсын гавьяат жүжигчин Ж.Дорждагва нар оржээ. Концерт хөтлөгч нь Ардын жүжигчин Д.Цэрэндулам байжээ. Тоглолтыг редактор Л.Мажигсүрэн “Р-5” сурвалжлагын магнитофоор /хурд 38 см/сек, хугацаа 43 минут/ бичиж авч хадгалжээ. Доктор (Ph.D), профессор Жамбалын Энэбишийн их дуучин Дорждагватай ярилцсан ярилцлагын эх гар бичмэл /он тодорхойгүй/-ийн 7 дугаар хуудсанд “Ильич минь” 4 хоолойны хор 1971 он гэж бичиж хадгалагджээ. Мөн “Соёл” сэтгүүлийн 1970 оны дугаар 2-т үг /Н.Наваан-Юндэн/, нооттойгоо анх хэвлэгдэн хадгалагдан үлдсэн байна.

[illegible]

Зураг 2. “Ильич мину”, Соёл сэтгүүл. 1970³

Өмнөх үед зохиож байсан хөгжим, дууны аялгууны хөдөлгөөний эрэмбэ, өгүүлбэр дундын каданс нь голдуу уламжлалт монгол ардын дууны кадансуудтай адил доминантын өргөөр төгсдөг байсан нь нэлээдгүй хэдэн бүтээлд нь элбэг

³ Эх сурвалж: Наваан-Юндэн 1970

байдаг. Үүгээрээ ч урлаг соёлын өв, үндэстний оюуны дархлаа болон мөнхөд оршдог. Энэ дууны бүтцийг гадна талаас нь ажиглахад, фразын дундах каданс доминантын эгшгээр төгсөж байгаа нь тухайн хүнийхээ онцлог, уран бүтээлийнх нь арга барилын илэрхийлэл бөгөөд харин тухайн цаг үед ЗХУ-ын коментернийн үзэл сурталд монголчуудын сэтгэлгээ маш гүнзгий эзлэгдсэн болохыг энэ дууны хийц шүлэг талаасаа ч, аялгуу талаасаа ч харуулдаг. Тэдэнд тухайн нөхцөлд өөр өнцгөөс илэрхийлэх боломж байгаагүй учраас уран бүтээлчид амьдарч байсан цаг үеэ яг байгаагаар нь үлдээхээс өөр аргагүй байсан цаг үе юм.

Ленин гэдэг нэр Ардын хувьсгалаас хойш монголчуудын оюун санаанд Богд хааны дараа орохоор шахуу байр эзэлсэн нь үнэн түүхийн балархай жим бөгөөд энэ дууг их өндөр түвшинд бүтээхийн тулд ойролцоо цаг үед амьдарч байсныг хэлэх үү хангалттай судалгаа хийсэн байгаа нь мэдрэгддэг ба эрэгтэйчүүдийн хоолойны терцээр хослох арга барилаар дуугаа эхлүүлсэн байдаг. Ленин гэхээр *Maestoso*-оос өөр темп тохирохгүй учраас хувьсгалын бэлэг тэмдэг болсон удаан марш хэмнэлийг авч наймт арван зургаатын пунктируудыг олноор ашигласан нь тухайн дууг нийгмийн өнгө аястай болгож чадсан байдаг ба до мажорын дэвсгэр хөгийг сонгож эхлүүлсэн эрэгтэй гурван хоолой нь түрж байгаа эмэгтэй хоёр хоолойтойгоо нийлээд таван хоолой дуугаралт бүхий дан найрал дууны стандарт хэлбэрийг бүрдүүлжээ. Энд нэг анзаарагдаж байгаа зүйл нь урд өмнийн найрал дуучдад зориулсан бүтээлүүдэд нь хоолой тус бүрийн хувь партийг пентатоникийн аялгуучлалаар хамсраажуулах хандлага их байсан бол энэ бүтээл дээр аккордын өргүүд буюу 4-5 хоолойн эгшгүүдийг бүрэн дуугаргахыг хичээсэн боловч, альт, тенор хоолойн хөдөлгөөнийг дуугаргахын тулд онолын зүгээс хүчээр тааруулах гэсэн оролдлого ажиглагдаж байна. Гэсэн хэдий ч урьдын арвин туршлага байгаа тул аялгууны эрэмбэ өсдөгөөрөө өссөөр оргилдоо хүрч байгаа нь сопрано хоолойн хоёр дугаар октавын ля ноот бөгөөд баргил /баритон/, аргил /басс/ хоолойнуудыг унисоноор шийдсэн нь их удирдаач зохиогчийн ухааны цар хүрээнд найдвартай суурь нэмж өгсөн мэт мэдрэгдэнэ.

“Онгийн голын домог” найрал дуу. Жигзавын Дорждагвын 1975 онд зохиосон “Онгийн голын домог” дууг Ф.И.Клешко багшийн зааснаар ноотлож тэмдэглэсэн байна. 1975 оны 3 дугаар сарын 29-ний өдөр үг, аялгууг зохион бичсэн 4 бадаг дахилттай дууны гар бичмэл хадгалагдан үлджээ.

1960-1980 онд тэр үеийн найрал дууны аялгуугаар орчин цагт дуулах уу, аль эсвэл дахин найруулах уу гэсэн үе байсан. Энэ тохиолдолд зохиогчийн санааг өөрчилбөл төрөлх шинж чанар нь алдагдана, үзэгч, сонсогч, дуулаачдын сонирхол, хүртээмж ямар болох гэх мэт олон асуудал тулгарна. ЗХУ-ын Москва хотын П.И.Чайковскийн нэрэмжит Хөгжмийн их сургуулийг найрал дууны удирдаачаар төгссөн Дагвын Лувсаншарав Ж.Дорждагватай хамтран найрал дууг сайжруулан түгээн дэлгэрүүлсэн байна. Энэ үедээ “Онгийн голын домог”-оо европ монголыг хослуулсан каливер болгож бичиж, театрын тайзан дээр дуулуулсан ч тухайн үед бичлэг хийгдээгүй учир дуулсан хэлбэрээрээ архивт хадгалагдаагүй байна.

Ж.Дорждагва нь өөрөө Онгийн голын хөндийд төрж өссөн нь дууны сэдэв, үг, аялгууг зохиоход нь нөлөөлсөн. Урд өмнө нь Магсархурцын Дугаржав, Баатар ван Насан-Очирын Наваан-Юндэн зэрэг авьяастнуудтай хамт ажиллаж байхдаа

нүүдэлчин уламжлалын тэгш таван эгшгийн зохицолд дассан, мөн байгалийн хэмнэлтэй айзам, бэсрэг уртын дууны аялгууны бүтэц, цар хүрээг мэдэрсэн байна. Энэ нь өнөөгийн монголчуудын хэрэглээ болж байгаа нийтийн дууны төрлийн эхлэл гэж болох бөгөөд аялгууны бүтэц дээрээ тэгш пентатоникийн хатуу байр суурьтай байсан нь зохиосон бүх дуунаас нь харагддаг. Гэхдээ хөгжимт жүжгийн болон концертын бүтээлдээ уртын дууны хэв маягийг чадварлаг ашигладаг байсан нь “Онгийн голын домог” дууг зохиоход ихээхэн нөлөөлсөн юм.



Зураг 3. Онгийн голын домог. Ж.Дорждагвын гар бичмэл⁴

Дэвсгэр хөгийн хувьд уламжлалт морин хуурын хөглөгөөнд таарсан Си бемоль мажорыг сонгосон байх бөгөөд харин размеров хувьд шинэлэг сэдэл хайсан уу, эсвэл туршилт хийсэн үү яагаад ч юм тухайн үед манай уламжлалд онолын томъёололд нээж илрүүлээгүй байсан 8/6-г ашигласан боловч энэ нь ноот бичлэгийн формын хувьд нэлээд төвөгтэй болсон нь харагддаг. Тактан дахь ноотны хувь нь таарахгүй байгаа боловч хөгжимд тоглоход ая нь зөв яваад байгаа нь түүний шантрашгүй зүтгэл, шавхагдашгүй хөдөлмөрийн нотолгоо болон үлджээ. “Онгийн голын домог” дууны темпийг *maestoso* гэж бичсэнээс харахад эх нутгаа бүхний дээр тавьдаг болох нь харагдахын зэрэгцээ уг зохиолоо найрал дуучдад зориулан бичсэн байгаа нь монголын уухайн түрлэгт их дууны уламжлалыг дагажээ. “Онгийн голын домог” дуунд нэгэн содон илэрхийлэл байдаг нь эхлэл тактнуудад байдаг шаталсан секвенцүүд бүхий босоо ятгын арпеджионууд юм. Энэхүү арпеджио нь голын урсгал, нутаг руугаа татагдсан сэтгэлийн ээнэгшлийг нүдэнд шууд харагдахаар дүрсэлсэн байх бөгөөд төгсгөлдөө бас өгсөх чиглэлээр

⁴ Эх сурвалж: Ж.Оюундэлгэрийн хувийн архив

дуусна. Хожим энэ дуугаа 1976 онд хөгжмийн онолд боловсорсон Ж.Дорждагва чанд бичлэгийн дүрмийн дагуу дахин шинээр ноотолсон байх бөгөөд тухайн үеийн шинэхэн хөгжмийн зохиолчдын гарын авлага болон үлдсэн байдаг.

Дүгнэлт

Аль ч нийгмийн үед уран бүтээлчид, ялангуяа зохион туурвигч хүмүүс амьдарч буй цаг үеийнхээ нийгмийн үзэл сурталд захирагдах нь зайлшгүй байсныг судалгаа шинжилгээнд харгалзах нь зүйтэй.

XX зууны шинэ монголын мэргэжлийн хөгжмийн зохиолчдын дунд хөгжмийн сургуульд сураагүй өөрийнхөө төрөлх авьяасаараа урлагийн түүхийг бүтээсэн хоёр хүн домог болон яригдаж үлдсэн бөгөөд анхных нь БНМАУ-ын Алдарт гавьяат дуучин, XX зууны манлай эрэгтэй уртын дуучин, хөгжмийн зохиолч, Улсын төв театр, анхны Уран сайхны сургуулийг үндэслэгчдийн нэг Жигзавын Дорждагва, удаах нь БНМАУ-ын Төрийн шагналт, Ардын жүжигчин, хийлч, хөгжмийн зохиолч, УДБЭТ-ыг үндэслэгчдийн нэг, дуурь, балетын удирдаач Жамъянгийн Чулуун юм.

Гадаадын олон орны дуу хөгжмийн ая дан сүлжилдэж байсан тухайн цаг үе, ялангуяа орос, хятад дуунд залуучуудын сонирхол хэт татагдаж байсан нөхцөлд Монгол гэж танигдахаар диатоникийн ертөнцийг бий болгох гэж тэмцэж байсан далд үйлстэй суутнуудын нэг гэдэг нь Жигзавын Дорждагва билээ. Шинэ үеийн монгол аялгуу болон гармонизацийн хөгжил дундад зууных шиг хоцрогдоогүй хирнээ дэлхийн шинжлэх ухаанжсан хөгжлөөс мөн хоцроогүй орж чадсаныг XX зууны монгол авьяастнуудын туурвисан зохиол бүтээлүүд гэрчилдэг.

Ж.Дорждагвын үүсгэн эхлүүлсэн монгол найрал дууны урлагийг судлан задлан шинжилж, сэргээн уран бүтээлийн сан хөмрөгт хадгалах, хамгаалах, цаашид хөгжүүлэх, судалгааны эргэлтэд оруулах нь орчин цагийн хөгжим судлаачид, найрал дууны удирдаачид, уран бүтээлчдийн үнэ цэнтэй үйл мөн билээ.

Ж.Дорждагва нь өөрийн бүтээлийн олон чиглэлүүдийн нэг болох дан найрал дууны хэлбэрээр хийх сонголтод хүрсэн хөгжмийн зохиолч, найрал дууны анхны тулгын чулууг тавьж өгсөн уран бүтээлч бөгөөд монголын мэргэжлийн найрал дууны урлагийг үндэслэгч юм.

Ашигласан материалын жагсаалт

Дорждагва, Ж., Наваан-Юндэн, Н. 1949. *Малынхаа дэргэд*. Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр.

Лхагвасүрэн, Д. 2025. *Хөгжмийн театрын түүхэн баримтат тэмдэглэл I*. Улаанбаатар: Хүслийн өнгө.

Наваан-Юндэн, Н. 1970. “Ильич мину”, *Соёл сэтгүүл*, №2.

Баримтат кино:

Жанцанноров, Нацаг. (зох.), Цагаанчулуун, Дарханбаатар (найр.). 2014. *Талын их дуучин*. Баримтат кино. 01:18:55. Өнгөт.

Ярилцлага:

Гомбожавын Мэнд-Ооёотой хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: Чингис хаан Үндэсний музей, 2025.

Гомбын Эрдэнэбаатартай хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: ДБЭТ, 2022.12.05-2024.12.12.

Д.Түвшинтөртэй хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: СУИС 106, 2024.

Дамдинсүрэнгийн Лхагвасүрэнтэй хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: ДБЭТ, 2023.

Лувсанжамцын Цогзолмаатай хийсэн ярилцлага. 12 микрорайон 2 байр, 2013.

Сэндэнжавын Дуламтай хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: СУИС, 2025.

Цэрэнгийн Туяацэцэгтэй хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: Хилийн цэргийн дуу бүжгийн чуулга. 2025.03.17.

Архивын баримт:

МУҮТА. 1950 оны Чойбалсан аймгийн театрын жилийн төлөвлөгөө гүйцэтгэл, үндэсний оркестр, захиргаа аж ахуйн ангийн жилийн ажлын тайлан илтгэл, төсөл театрын шинэ барилгын тухай материалууд. х. 13, д. 1, хн 260.

МУҮТА. Ардын гэгээрүүлэх яамны дэргэд байсан Улс төрийн уран сайхны зөвлөлийг өргөтгөж, СнЗ-ийн дэргэд 1938 оны 1 дүгээр сарын 28-нд “БНМАУ-ын Уран сайхны хэрэг эрхлэх хүрээлэн” байгуулсан тухай. х.13, д. 1, хн. 14, 31.

Гар бичмэл:

Дорждагва, Ж. 1975. “Онгийн голын домог” гар бичмэл. 1975.03.29.